



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Хархорин-Ус суваг” /ТБОНӨО/ ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨВА-2026/01/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2026 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Аравхайр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253.
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 144
танай _____-ны № _____-т

“ХАРХОРИН-УС СУВАГ” ТӨРИЙН
БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ОРОЛЦООТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ё.ОТГОНСҮХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хархорин-Ус суваг” Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоот ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Хархорин-Ус суваг” Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоот ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бидний хэрэгжүүлсэн горим сорилоор бараа материалын дансны үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд туссан өр төлбөр нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг 49.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4-т “Тооллогын комисс дараах үүрэгтэй” 4/1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 73 дугаар зүйлийн 2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна. Санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг”, “Оршин байх” зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус компани нь тайлант онд 723.8 сая төгрөгийн борлуулалтын орлого, 103.2 сая төгрөгийн бусад орлого, нийт 827.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 692.8 сая төгрөгийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт, ерөнхий удирдлагын зардалд 331.7 сая төгрөгийг зарцуулж, 197.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөгөөр зардлын төлөвлөгөөг 181.5 сая төгрөгийн алдагдалтай баталжээ. Гүйцэтгэлээр борлуулалтын орлого 30.3 хувь буюу 192.1 сая төгрөгөөр давж биелсэн ч үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал төлөвлөснөөс 154.0 сая төгрөгөөр, засвар сэлбэгийн зардал 117.8 сая төгрөгөөр хэтэрсэнтэй холбоотой алдагдалтай ажиллажээ.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	37,541,138.79	100,399,670.82
1.1.2. Дансны авлага	0	10,919,322.00
1.1.6. Бараа материал	11,022,679.00	23,063,588.19
1.1.7. Бусад эргэлтийн хөрөнгө	43,696,546.00	43,696,546.00
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	92,260,363.89	178,079,127.01
1.2.1 Үндсэн хөрөнгө	5,541,730,889.33	5,304,234,178.16
1.2.2 Биет бус хөрөнгө	41,407,500.00	39,990,000.0
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,583,138,389.33	5,344,224,178.16
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,675,398,753.22	5,522,303,305.17
2.1.1.1 Дансны өглөг		
2.1.1.3 Татварын өр	1,684,821.01	30,240,657.71
2.1.1.4 НДШ-ийн өр		
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,684,821.01	30,240,657.71
2.2 Өр төлбөрийн нийт дүн	1,684,821.01	30,240,657.71
2.3 Эздийн өмч	5,925,061,170.16	5,925,061,170.16
2.3.1 Төрийн	5,925,061,170.16	5,925,061,170.16
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0	15,873,842.00
2.3.7 Эздийн өмчийн бусад хэсэг	148,154,638.35	148,154,638.35
2.3.9 Хуримтлагдсан ашиг	-399,501,876.30	-570,448,266.56
Өмнөх		-399,501,876.30
Тайлант үе		-197,525,126.75
2.3.11 Эздийн өмчийн дүн	5,673,713,932.21	5,492,062,647.46
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,675,398,753.22	5,522,303,305.17

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант үе
1	Борлуулалтын орлого (цэвэр)	466,793,623.15	723,839,769.32
2	Борлуулалтын өртөг	572,114,766.20	692,842,161.12
3	Нийт ашиг (алдагдал)	-105,321,143.05	30,997,608.20
8	Бусад орлого	46,061,083.78	103,195,243.85
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	151,115,135.26	331,717,978.80
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-210,375,194.53	-197,525,126.75
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-210,375,194.53	-197,525,126.75
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-210,375,194.53	-197,525,126.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1 Мөнгөн орлогын дүн	574,876,804.36	876,068,546.78
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	574,876,804.36	876,068,546.78
1.2 Мөнгөн зарлагын дүн	570,812,864.60	813,210,014.75

**“Хархорин-Ус суваг” /ТБОНӨО/ ХХК-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

1.2.1 Ажиллагчдад төлсөн	206,725,710.53	296,651,182.89
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	57,913,474.93	90,573,092.73
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	148,392,581.00	217,770,864.00
1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	46,837,716.67	65,934,992.56
1.2.5 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	46,130,653.00	69,878,600.0
1.2.7 Татварын байгууллагад төлсөн	19,122,249.7	38,740,366.05
1.2.8 Даатгалын төлбөрт төлсөн	265,500.00	472,350.00
1.2.9 Бусад мөнгөн зарлага	45,424,978.60	33,188,566.52
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,063,939.76	62,858,532.03
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,063,939.76	62,858,532.03
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,477,199.03	37,541,138.79
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,541,138.79	100,399,670.82

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
3	2025 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	5,925,061,170.16		148,154,638.35	-399,501,876.30	5,673,713,932.21
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
5	Залруулсан үлдэгдэл				-197,525,126.75	-197,525,126.75
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
7	Бусад дэлгэрэнгүй орлого					
8	Өмчид гарсан өөрчлөлт					
9	Зарласан ногдол ашиг					15,873,842.0
10	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		15,873,842.0			
11	2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,925,061,170.16	15,873,842.0	148,154,638.35	-597,027,003.05	5,492,062,647.46

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/Д	Зардлын үзүүлэлт	2025 оны /Мян төг/			Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
	ЗАРЛАГА				
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	372,225.4	363,407.8	- 8,817.60	97.6
2	Н.Д.Шимтгэл	46,528.1	50,683.5	4,155.40	108.9
3	Цахилгаан эрчим хүчний зардал	78,129.6	53,614.6	- 24,515.00	68.6
4	Шатахууны зардал	30,638.7	45,444.2	14,805.50	148.3
5	ХАБЭА-н зардал	6,960.0	7,160.0	200.00	102.9
6	Томилот , байр,унааны зардал	11,840.0	6,193.9	- 5,646.10	52.3
7	Харилцаа холбоо,зар сурталчилгааы зарда	3,011.0	1,748.1	- 1,262.90	58.1
8	Татвар,даатгалын зардал	28,531.0	11,862.0	- 16,669.00	41.6
9	Засвар ,сэлбэгийн зардал	58,800.0	176,604.0	117,804.00	300.3
10	Тусгай зөвшөөрөл,зохицуулалтын хөлс	5,000.1	5,000.1	-	100.0
11	НААҮХолбооны татвар	1,500.0	1,500.0	-	100.0
12	Ү.Х-ийн элэгдэл	103,140.8	257,128.9	153,988.10	249.3
13	Нийгэм халамжийн зардал	6,700.0		- 6,700.00	0.0
14	Бусад үйл ажиллагааны зардалны зардал	15,319.3	12,682.8	- 2,636.50	82.8
15	Гадна байгууллагын үйлчилгээний хөлс	13,640.0	7,335.8	- 6,304.20	53.8
16	Бичиг хэргийн зардал	2,000.0	3,401.4	1,401.40	170.1
17	Бусад	25,000.0	20,793.0	- 4,207.00	83.2
18	Хөрөнгө оруулалт	7,500.0	-	- 7,500.00	0.0
		816,464.0	1,024,560.1	208,096.10	125.5
	НИЙТ ЗАРДАЛ			-	
	ОРЛОГО				
1	Цэвэр ус борлуулалтын орлого	346,632.0	486,626.3	139,994.30	140.4
2	Бохир ус татан зайлуулсан орлого	237,222.8	237,213.2	- 9.61	100.0
3	Суурь хураамжийн орлого	17,546.5	18,951.4	1,404.86	108.0
4	Бусад орлого / холболт,ажлын хөлс/	33,494.0	84,243.8	50,749.80	251.5
		634,895.4	827,035.0	192,139.65	130.3
	НИЙТ БОРЛУУЛАЛТ				
	Ашиг,алдагдал	(181,568.7)	(197,525.10)	- 15,956.45	108.8

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 5.1 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрч аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний журналаар данс андуурч орсон болон буцсан гүйлгээг орлого зарлагаар тусгаж Мөнгөн гүйлгээний тайланг буруу илэрхийлсэн нь УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" стандарт болон "иж бүрэн байх", "оршин байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар залруулагдаагүй 49.7 сая төгрөгийн зөрчил² илэрч 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлж байна.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Албан шаардлага

Аудитын илрүүлэлт:

1. Санхүүгийн байдлын тайланд 30.2 сая төгрөгийг татварын байгууллагад төлөх өглөгөөр бүртгэсэн боловч 26.6 сая төгрөгийн өглөг нь ямар төрлийн татвар, төлбөр хураамжийн өр болох нь тодорхойгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэх

2. Жилийн эцсээр 23.1 сая төгрөгийн бараа материалд тооллого хийгээгүй, тооллого хийсэн тухай комиссын илтгэх хуудас, Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцсэн баримт материал байхгүй байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэх

3.3 Зөвлөмж

Аудитын илрүүлэлт:

1. Шилэн дансны цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш орлогын 24 гүйлгээ, зарлагын 5 гүйлгээ, 10 шийдвэрийг хуульд заасан хугацаа хоцроож байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөрчлүүдэд үндэслэн "Хархорин-Ус суваг" /ТБОНӨӨ/ ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэлт өглөө. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого зарлага илүү тайлагнасан.	1	5,135.0			1	5,135.0	1	5,135.0				
Дүн	1	5,135.0	0	0	1	5,135.0	1	5,135.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тооллого хийгээгүй	1	23,063.6			1	23,063.6						
Өглөг тооцоо нийлээгүй	1	26,578.7			1	26,578.7						
	2	49,642.3	0	0	2	49,642.3		0	0	00	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийт зөрчил		Үүнээс	

**“Хархорин-Ус суваг” /ТБОНӨО/ ХХК-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Зөрчлийн товч утга			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроосон	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	00	00	00	00	00	00	0
Нийт дүн	1	0					1	

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 13

